

"СОЛОНГОСЫН ХОЙГИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ: БНАСАУ-АНУ-ЫН ХАРИЛЦААНЫ ЭРГЭН ТОЙРОНД"

Д.Отгонбаатар, (МА)

otgoomub21@gmail.com

Two years have passed since the Hanoi summit between USA and North Korea failed and negotiations over North Korean denuclearization were suspended. The newly elected U.S administration has attempted to restart negotiation with North Korea. The Eight Congress of the Workers Party of Korea held in January 2021 drew significant attention as it was the first large-scale event convened in North Korea around the time of the inauguration of the Biden Administration. The US Secretary of State and Secretary Defense visited South Korea, after USA-Japan 2+2 meeting, on March 18th and held USA-Korea 2+2 meeting for the first time in 5 years, showing a South Korea-US alliance. This paper will analyze the prospects for the US and North Korea's policies towards each other, and examine various issues that will emerge when Biden's administration prepares for denuclearization policy with North Korea.

Keyword: USA, North Korea, Korean peninsula, Foreign policy

Энэ оны 3-р сард Зүүн хойд Азийн бүс нутгийг тэр дундаа Солонгосын хойгийн асуудлыг сонирхон судлаачдын хүрээнийхний анхаарлыг ихээхэн татсан үйл явдал, өрнөл дүүрэн өнгөрөв. Өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж буй Ковид-19 халдварлалтын тоо, хатуу хөл хороо тогтоох эсэх, аль улсад үйлдвэрлэсэн вакцин тариулах эсэх, ерөнхийлөгчийн сонгууль угтсан улс төрийн намууд хөдөлгөөнд орж эхэлж байгаа гэх мэт өдөр тутмын анхаарал татсан олон асуудлын хажуугаар Зүүн хойд азийн бүс нутаг, Солонгосын хойгийн асуудал олон нийтийн анхаарлыг татсан асуудал биш байж болох юм. Гэвч нөгөө талаар чухам ийм л цаг үед тус бүс нутагт ямар үйл явц хэрхэн өрнөх нь Монголыг хүрээлсэн гадаад орчин үл итгэлцлээр дүүрэн хүчний бодлогын өрсөлдөөний талбар байх уу, хамтын хөгжлийн замыг эрэлхийлсэн таатай орчны эхлэл байх уу гэдэг нь манай улсын хувьд чухал ач холбогдолтой гэж М.Батчимэг агсан 2004 онд энэ сэдвийг хөндөж байсан нь өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй үнэ цэнэтэй хэвээр байх тул өнгөрсөн 3-р сард Солонгосын хойгт болсон үйл явдалд тулгуурлан Солонгосын хойгийн нөхцөл байдлын өрнөлийн талаар танилцуулж байна.

АНУ-БНХАУ худалдааны дайн, ОХУ-БНХАУ харилцааны ойртол, Ханойн дээд хэмжээний уулзалтаас хойш түр зогсонги байдалд ороод байсан АНУ-БНАСАУ харилцаа, Өмнөд-Хойд хоёр Солонгосын харилцааны өнөөгийн нөхцөл байдал бидний амьдралд өнөөдөртөө шууд нөлөөлдөггүй юмаа гэхэд алсдаа нөлөөлөх нь дамжиггүй.

АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн Зүүн хойд Азийн талаарх бодлого

2021 он гарч 1-р сарын 12-нд АНУ-н ерөнхийлөгч Д.Трамп АНУ-н “Энэтхэг-Номхон далайн стратеги”¹(United State strategic framework for the Indo-Pacific)” баримт бичгийг нууцын зэрэглэлээс гаргасан ба 10 хуудас энэхүү материалыг Трампын засгийн газар 2017 оны 3-р сарын 28-нд анх танилцуулж байсан бөгөөд энэхүү стратеги нь АНУ-н өнгөрсөн 3 жилийн хугацаанд Энэтхэг-Номхон далайн бүс нутагт баримталж ирсэн гадаад бодлого байсан юм. Энэхүү баримт бичигт БНХАУ-н зүгээс Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгааг дурдаж АНУ, Япон, Энэтхэг, Австрали зэрэг улс нэгдэн хамтран ажиллах тухай агуулга багтаж байв.

АНУ-н ерөнхийлөгч Ж.Байден 1-р сарын 23-нд тангараг өргөж албан үүргээ гүйцэтгэж эхэлснээс хойш Солонгосын хойгийн талаар ямар бодлого баримтлах нь олон улсын судлаачдын анхаарлын төвд байсан бөгөөд Цагаан ордон 3-р сарын 3-ний өдөр танилцуулсан Үндэсний аюулгүй байдлын Стратегийн явцын удирдамж²(Interim National Security Guidance) бүхий 24 хуудас материалыг харахад Трамп ерөнхийлөгчийн хэрэгжүүлж ирсэн гадаад бодлоготой ижил төсөвтэй байх төлөвтэй байна. Уг удирдамжийн гол агуулга нь АНУ холбоотны улсуудын хамтаар Хятад улсад шахалт үзүүлнэ. Ялангуяа БНСУ-ыг Австрали, Япон зэрэг улсуудын адилаар АНУ-н стратегийн хамтрагч гэж үзсэн. Солонгосын хойгийн цөмийн асуудлын хувьд Байден ерөнхийлөгч нэр дэвшигч байх үеэс өнөөг хүртэл олон удаа дурдаж байсанчлан Холбоотны улсуудын хамтын ажиллагааг бэхжүүлж БНАСАУ-г хэлэлцээрийн ширээнд суулгахын тулд Япон, БНСУ зэрэг холбоотны улсуудын хамтаар олон талт хамтын ажиллагаагааны шахалт үзүүлнэ. Хэлэлцээ хийх арга хэлбэрийн хувьд доороос-дээшээ(bottom-up) буюу АНУ-БНАСАУ-н хоёр талын ажлын хэсгийн түвшинд асуудлаа шийдвэрлэсний дараа Ким Жөн Унтай уулзаж Солонгосын хойгийн цөмийн асуудлыг шийдвэрлэж болох юм гэж мэдэгдсэн. Өмнөх ерөнхийлөгч Д.Трампын явуулж ирсэн дээрээс-доош(top-down) бодлогыг ихээхэн шүүмжилж, Сингапур, Ханойн

¹ <https://trumpwhitehouse.archives.gov/wp-content/uploads/2021/01/IPS-Final-Declass.pdf>

² <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2021/03/NSC-1v2.pdf>

уулзалт шиг зөвхөн олон нийтэд харуулах зорилго төдий уулзалтыг Ким Жон Унтай хийхгүй бөгөөд БНАСАУ цөмийн зэвсгээсээ бүрэн татгалзсан тохиолдолд Ким Жон Унтай уулзах болно гэж өмнөх засгийн бодлогод шүүмжлэлтэй хандаж байв. Мөн тэрбээр Солонгосын хойгийн цөмийн зэвсгийн асуудлыг шийдвэрлэхэд АНУ-БНСУ-Япон 3 улсын хамтын ажиллагааг чухалчлан авч үзэхээ илэрхийлж байсны нэг илэрхийлэл нь АНУ-н өндөр албан тушаалтнуудын Ази дах анхны албан айлчлал байв.

АНУ-н Төрийн нарийн бичгийн дарга Т.Блинкен, Батлан хамгаалахын сайд Л.Аустин нар 3-р сарын 15-18-ны өдрүүдэд Япон, БНСУ-д³ айлчиллаа. Энэхүү айлчлал нь 1-р сарын 23-нд Ерөнхийлөгчийн тангараг өргөж ажилдаа орсон Ж.Байдений засаг захиргааны төрийн өндөр албан тушаалтнуудын гадаадад хийж буй анхны албан айлчлал бөгөөд Зүүн хойд Азиас эхэлж байгаа нь ач холбогдолтой байв. Айлчлалаар АНУ-Японы 2+2 уулзалт, АНУ-БНСУ 2+2 уулзалтуудаар дамжуулан Солонгосын хойгийг тойрсон асуудлуудыг хэлэлцэв. Өнөөг болтол АНУ Солонгосын хойгийн талаар ямар бодлого баримтлахаа нийтэд зарлаагүй байгаа бөгөөд энэхүү Япон,БНСУ-д хийж буй энэхүү айлчлалын зорилго нь Солонгосын хойгт ирэх 4 жил баримтлах бодлогоо боловсруулж холбоотон улсууддаа танилцуулж, эцэслэн тогтох зорилготой байв. Энэ айлчлалаас өмнө нь АНУ Солонгосын хойгт ямар бодлого явуулах вэ гэдэг талаар судлаачид зөвхөн өөр өөрсдийн хувийн таамгийг л дэвшүүлэх түвшинд байсан юм.

АНУ-Японы 2+2 уулзалтын хамтарсан мэдэгдэл⁴

2020 оны 3-р сарын 16-ны өдөр Токио хотод зохион байгуулагдсан АНУ-Японы гадаад харилцаа, аюулгүй байдал, батлан хамгаалах асуудал эрхэлсэн сайд нарын зөвлөлдөх уулзалт болж, аюулгүй байдлын асуудалд тулгуурлан 2 талт харилцаа болон бүс нутаг, олон улсын нөхцөл байдлын талаар зөвлөлдөж хамтарсан мэдэгдэл гаргав. Тус хамтарсан мэдэгдэлд “АНУ-Япон хоёр улс нь Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн энх тайван аюулгүй байдал, хөгжин цэцэглэлийн явцыг үргэлжлүүлнэ. Япон улс батлан хамгаалах салбараа бэхжүүлэн хөгжүүлэх тал дээр хоёр тал санал нээгдэж, нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүс нутаг болон олон улсын дэг журамд суурилсан хамтын шийдвэрийг гаргав” гэжээ.

БНХАУ-н талаар: Хятад улс олон улсын дүрмийг баримтлахгүй байгаа нь хоёр улс улс төр, эдийн засаг, цэрэг, технологийн салбарт ажиллах шаардлагыг бүрдүүлж байна гэж үзээд олон улсын дэг журамд саад учруулж буй үйл явцыг хүлээн зөвшөөрөхгүй. Мөн хоёр тал Өмнөд Хятадын тэнгис дэх энх тайван, аюулгүй байдлын чухлыг дурдаж, Хонконг, Шинжан Уйгарын өөртөө засах бүс нутгийн хүний эрхийн асуудалд санаа зовж байгааг талууд илэрхийлэв.

БНАСАУ-н талаар: Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс бүрэн ангигруулах асуудалд талууд санал нэгдэж НҮБ-н Аюулгүйн зөвлөлийн тогтоолын дагуу бүх үүргээ биелүүлэхийг шаардав. Мөн Умард Солонгост барьцаалагдсан иргэдийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг талууд илэрхийлэв.

Батлан хамгаалах салбарын талаар: Бүхий л түвшинд батлан хамгаалах чадварыг бэхжүүлэхийн тулд нягт хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Сансарын болон кибер аюулгүй салбарт мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллахын чухлыг онцлов.

Мөн Футенма онгоцны буудлыг орлох Камп Шваб Хэнокосаки/Camp Schwab-Henokosaki/-бүсд ойрхон байгуулах төлөвлөлт Футенма онгоцны буудлыг байнга ашиглахаас зайлсхийх цор ганц шийдэл мөн гэдгийг дахин тодорхойлж аль болох ойрын хугацаанд барилгын ажлыг дуусгахаар болов

Япон улсын Ерөнхий сайд Сүга Ёшихида нь удаа дараа БНАСАУ-н төрийн тэргүүн Ким Жон Унтай ямар нэг “болзолт” нөхцөлгүйгээр уулзахад бэлэн байна гэдгээ зарлаж ирсэн бол 4-р сарын 4-нд хийсэн хэвлэлийн ярилцлагадаа мөн “Ким Жон Ун төрийн зөвлөлийн даргатай биечлэн уулзаж барьцаалагдсан Япон иргэдийн асуудлаар уулзалтын яриа хэлэлцээний ширээнд суухад бэлэн байгаагаа мэдэгдсэн.

Энэ удаагийн АНУ-Япон 2+2 уулзалтыг ажиглахад хэд хэдэн онцлогтой байна. 1-рт АНУ-н зүгээс АНУ-БНСУ-Японы гурвалсан хамтын ажиллагаа Солонгосын хойгийн цөмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж тодорхойлов. Хэдийгээр БНСУ-Япон хоёр улсын хувьд өнөөг хүртэл шийдвэрлээгүй үлдсэн түүхийн маргаантай асуудлууд, худалдааны зөрчилдөөнтэй асуудлууд байсаар байгаа боловч бүс нутгийн аюулгүй байдлыг чухалчлан авч үзэж нийтлэг эрх ашгийн үүднээс хандах хандлага ажиглагдаж байна. АНУ-н санаачилгаар 3 улсын аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүнүүд Вашингтонд уулзаж байгаа нь түүний нэг илрэл болж байна.

2-рт АНУ-Японы 2+2 уулзалт, холбоотны улсуудын хамтаар Хятад улсыг тогтоон барих асуудал Байдений гадаад бодлогын гол цөм болж байгаагийн илэрхийлэл болов уу. Трамп ерөнхийлөгчийн засгийн газрын сүүлийн жилүүдэд идэвхитэй өрнөсөн АНУ-БНХАУ-н өрсөлдөөн Байдений засгийн газрын үед ч мөн үргэлжлэх төлөвтэй байна. Трампын захиргаа БНХАУ-г илт буруушааж шинэ “хүйтэн дайн”-ны үеийн хэмжээний бодлого⁵

³ <https://www.state.gov/secretary-blinkens-travel-to-tokyo-and-seoul/>

⁴ <https://www.state.gov/u-s-japan-joint-press-statement/>

⁵ IFANS

явуулж байсан бол Байдений захиргаа шууд тулахаас зайлсхийж хамтран ажиллах нийтлэг эрх ашгийг хөндсөн салбартаа хамтарч, харин эрх ашиг хөндөгдөж буй салбарт бол өрсөлдөх, өөрийн улс орны нэн тэргүүний эрх ашгийг чухалчлан авч үзэх тактикийг баримталж байна. Жишээлбэл Байдений захиргаа хүний эрх, гадаад худалдаа, аюулгүй байдлын асуудал дээр Хятад улсыг хязгаарлан тогтоох бодлого баримталж байгаа бол Уур амьсгалын өөрчлөлт, дэлхий нийтээр тархаад буй Ковид-19, Хойд Солонгосын цөмийн асуудлууд дээр Хятад улстай хамтран ажиллах төлөвтэй байна.

АНУ-БНСУ 2+2 уулзалт

БНСУ-н хувьд мөн л адил 3-р сар олон айлчлал давхацсан сар байв. АНУ-н Төрийн нарийн бичгийн дарга, Батлан хамгаалахын сайд нар айлчилсан бол түүний дараа ОХУ-н Гадаад хэргийн сайд С.Лавров Сөүлд айлчилж, үүний дараа БНСУ-н Гадаад хэргийн сайд Жон И Юн БНХАУ-д айлчлал хийж Ван И Гадаад хэргийн сайдтай уулзалт хийв.

Энэ удаагийн АНУ-БНСУ-н 2+2 зөвлөлдөх уулзалт 5⁶ жилийн дараа зохион байгуулагдаж байгаагаараа онцлог байв. АНУ-н зүгээс 2+2 уулзалтыг тогтмол зохион байгуулж байгаа улсын тоонд Япон, Австрали, Энэтхэг, Солонгос гэсэн 4 улс байдаг бөгөөд БНСУ бол АНУ-н стратегийн түнш улсын нэг юм. Энэ удаагийн уулзалтаар холбоотны улсын хувьд “Солонгосын хойг, Энэтхэг номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтарсан цэргийн сургуулилтаар аливаа үүсэж буй эрсдийн эсрэг хамтран ажиллах”-аа хоёр тал нотлов. Уулзалтын дараагийн нэг том үр дүн нь нилээд хэдэн жилийн өмнөөс яригдаж ирсэн “Батлан хамгаалах зардал”/Special Measures Agreement/⁷-ыг эцэслэн тохирч баталгаажуулсан явдал байсан бөгөөд үүнээс гадна Сөүлд дэх хоёр улсын хамтарсан Цэргийн командлалын удирдлагыг шилжүүлэх явцыг эхлүүлэх, Эрүүл мэнд, Сансар судлал, Кибер аюулгүй байдал, Атомын станц байгуулах зэрэг олон салбарт хамтарч ажиллахаар тохиролцсон байна. Хоёрхон хоногийн өмнө зохион байгуулагдсан АНУ-Японы 2+2 зөвлөлдөх уулзалтаас ялгаатай нь АНУ-БНСУ-н зөвлөлдөх уулзалтын хамтарсан мэдэгдэлд БНХАУ-г нэр зааж дурдаагүй байв. БНСУ-н хувьд АНУ-БНХАУ хоёр их гүрний худалдааны дайнаас эхлэлтэй тэмцэлд аль нэг улсын талд орж байр сууриа илэрхийлэх эрсдэлтэй тул болгоомжилсон алхам гэж үзэж болно. БНХАУ-н хувьд Өмнөд Солонгосыг цэргийн хамтарсан механизмд элсэн ороход нухацтай ханддагтай холбож ойлгож болох юм. Өмнө нь БНСУ-н Пуужин эсэргүүцэх байгууламж /THAAD-Terminal High Altitude Area Defense/ байрлуулсны дараа БНХАУ зүгээс Солонгосын томоохон компаниудын эсрэг худалдааны хориг тавьж байснаас улбаатай.

Солонгосын хойгийн асуудлаар: АНУ-Японы зөвлөлдөх уулзалтын хамтарсан мэдэгдэлд “Умард Солонгосыг цөмийн зэвсгээс ангижруулах” гэж тусгасан бол БНСУ-тай хийсэн зөвлөлдөх уулзалтад энэ нэр томъёо тусгагдаагүй бөгөөд харин “Умард Солонгосын цөм, балластик пуужин бол хоёр улсын нэн тэргүүний анхаарлын төвд байгаа асуудал” гэж онцлов.

Мөн өөр нэг анхаарал татсан асуудал бол Хамтарсан мэдэгдэлд тусгагдаагүй ч хэвлэлийн хурлын үеэр АНУ-н тал Quad/4 талт уулзалт/-н талаар БНСУ-тай үргэлжлүүлэн хамтарч байгаа гэсэн байр суурийг илэрхийлсэн юм. БНСУ-н тал энэ талаар тодорхой шийдэлд хүрээгүй гэж мэдэгдсэн зэргээс харахад хоёр улс одоогоор нэгдсэн шийдэлд хүрээгүй байна. Харин БНСУ Энэтхэг Номхон далайн бүс нутагт Ковид-19, Уур амьсгал, Технологийн салбарт хамтран ажиллахаа илэрхийлсэн.

БНСУ-н Мүн Жэ Ин, ерөнхийлөгч болсон цагаасаа хойш БНАСАУ-тай харилцах харилцаанд онцгой анхаарч “Шинэ Солонгосын хойгийн бодлого”⁸-оо зарлаж, хоёр улсын харилцааг сэргээх чиглэлээр идэвхийлэн ажиллаж ирсэн. Үүний үр дүнд Панмүнжомын хоёр улсын төрийн тэргүүнүүдийн уулзалт, Умард Солонгосын нийслэл Пхьянян хотод айлчилж Төрийн зөвлөлийн дарга Ким Жөн Унтай 3 удаа уулзсан нь 10 гаруй жил “хөндийрөөд” байсан 2 Солонгосын харилцаанд нааштай нөлөөлсөн ч Солонгосын хойгийн цөмийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой үр дүнд хүрээгүй. БНСУ-н ерөнхийлөгч Мүн Жэ Ин ерөнхийлөгчөөр ажиллах хугацаа 2022 оны 3-р сард дуусах бөгөөд ерөнхийлөгчөөр ажиллах 1 жилийн үлдэж буй хугацаанд Умард Солонгостой харилцаагаа сэргээх чиглэлээр идэвхийлэн ажиллахаа зарлаж байсан ч өнөөдөр БНСУ-н дотоодод болж буй улс төрийн үйл явдлууд, ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгууль гэх мэт илүү чухал шийдвэрлэх асуудлууд ар араасаа цувран гарч буй тул ойрын хугацаанд хоёр Солонгосын харилцаанд өөрчлөлт гарна гэж хэлэхэд эрт байна.

4-р сарын 7-нд болсон Сөүл болон Пусан хотын даргын нөхөн сонгуульд Мүн Жэ Ин ерөнхийлөгчийн Минжү/ардчилсан нам/ ялагдаж, сөрөг хүчин Солонгосын хамгийн том хоёр хотын даргын албан тушаал очсон нь үлдэж буй 1 жил гаруй хугацаанд гадаад асуудал гэхээсээ илүүтэй дотоодын улс төрдөө илүү их анхаарах

⁶ БНСУ-АНУ 2+2 уулзалтыг 2010, 2012, 2014, 2016 онуудад тус тус зохион байгуулж байсан бөгөөд түүнээс хойш тасалдаад байжээ. ifans.go.kr

⁷ <https://thedi diplomat.com/2021/03/south-korea-and-us-reach-agreement-on-defense-cost-sharing/>

⁸ <https://www.unikorea.go.kr/unikorea/policy/koreapolicy/policyinfo/goal/>

нөхцөл болж өгч байна.

БНАСАУ-н байр суурь

Өнгөрөгч 3-р сарын хувьд БНАСАУ-н хувьд⁹ Солонгосын хойгт болж буй үйл явдлын гол оролцогч эзэн орны хувьд мөн л үйл явдал өрнөл дүүрэн байв. АНУ-н Төрийн нарийн бичгийн дарга Т.Блинкен Өмнөд Солонгост айлчлахаас 1 өдрийн өмнө Солонгосын Хөдөлмөрийн намын үзэл суртлын хэлтсийн дарга Ким Ё Жон мэдэгдэл¹⁰ гаргаж, түүний дараа Гадаад хэргийн дэд сайд Чой Сон Хи мөн мэдэгдэл хийж АНУ болон Өмнөд Солонгосын Засгийн газрын бодлогыг шүүмжилсэн.

Ким Ё Жон Хөдөлмөрийн сониноор дамжуулан нийтэлсэн мэдэгдэлдээ АНУ-БНСУ хамтарсан цэргийн сургуулилтыг шүүмжилсэн мэдэгдэл гаргав. Энэ мэдэгдэл 3-р сарын 8-ны өдөр эхэлсэн Цэргийн сургуулилтын эхлэх үеэр биш дуусах алдад өөрөөр хэлбэл АНУ-н төрийн нарийн бичгийн дарга Т.Блинкен, Батлан хамгаалахын сайд Л.Аустин нарын Өмнөд Солонгост хийх айлчлалын урд өдөр хийсэн нь зориуд урьдаас төлөвлөсөн Ж.Байдений засгийн газарт хандаж гаргасан Умард Солонгосын анхны мэдэгдэл тул анхаарал татаж байв. Мөн цаг хугацааны хувьд АНУ-н засгийн газрын Солонгосын хойгийн талаарх авч хэрэгжүүлэх бодлого эцэслэгдэх шаганд даа орж байгаа цаг үетэй таарч буй юм. Мөн Умард Солонгосын талаас ямар түвшинд, хэн мэдэгдэл гаргавал харилцагч тал илүү сонсоно гэдгийг давхар сайтар тооцсон.

Түүний мэдэгдэлд “АНУ-БНСУ-н цэргийн хамтарсан хээрийн цугларалтыг шүүмжлээд зогсохгүй, Өмнөдийн асуудал хариуцсан “Эх орноо энх тайвнаар нэгтгэх хороо”-г татан буулгах, Гымган уулын аялал жуулчлал зэрэг Өмнөдтэй холбоотой дундын байгууламжуудыг хаах, бүр цаашлан Өмнөд-Умардын цэргийн хэлэлцээрийг¹¹ хүчингүй болгоно¹²” гэж мэдэгдэв. АНУ-д хандан “ирэх 4 жил тайван нойртой хоноё гэж байгаа бол эхнээсээ зөв алхам хийх хэрэгтэй” гэсэн сүрдүүлэг хийхээ ч мартсангүй. Мөн Өмнөдийн засгийн газартай яриа хэлэлцээ хийх сонирхолгүй байгаагаа тов тодорхой илэрхийлсэн нь БНХАУ-ын тус дэмжлэгтэйгээр эдийн засгаа сэргээх боломжтой гэж үзэж байгаа учраас заавал өмнөдийн тусламж дэмжлэгийг харах шаардлагагүй гэж үзсэн байх магадлалтай. Мүн Жэ Иний засгийн газар Умардтай харилцаагаа сайжруулах хоёр талын хичээл зүтгэлээс илүүтэй БНХАУ-тай хамтран Умард Солонгосыг яриа хэлэлцээний ширээнд урих нь илүү үр дүнтэй байж мэдэх юм.

БНАСАУ-н Гадаад хэргийн дэд сайдын мэдэгдэл

Умард Солонгосын гадаад хэргийн 1-р орлогч сайд Чой Сон Хи 3-р сарын 18-ны өдөр мэдэгдэл¹³ хийв. Энэхүү мэдэгдэл Ким Ё Жоны хийсэн мэдэгдлээс илүү дэлгэрэнгүй Умард Солонгосын албан байр суурийг илэрхийлж байв. Тэрбээр “Сүүлийн үед АНУ бидэнтэй янз бүрийн шугамаар холбоо тогтоохоор оролдсон. Манай улсад чиглэсэн дайсагнасан бодлогоосоо АНУ татгалзахгүй бол Солонгос, АНУ-тай дахин хэлэлцээний ширээнд суухгүй гэсэн байр сууриа бид хэдийнээ илэрхийлсэн. Иймд цаашид АНУ-н зүгээс бидэнтэй холбоо тогтоох гэсэн аливаа оролдлогыг бид хүлээн авахгүй болно. Яриа хэлэлцээ хийхийн тулд эрх тэгш зарчим дээр тулгуурлан яриа хэлэлцээ хийх, санал солилцох уур амьсгал бүрдүүлэх ёстой. АНУ бидэнтэй яаж харилцана, бид мөн хариу адил харьцана” гэж мэдэгджээ.

Умард Солонгос албан ёсоор АНУ-н уулзах хүсэлт тавьж байсныг хүлээн зөвшөөрч, яриа хэлэлцээний ширээнд суух уур амьсгал яагаад бүрдэхгүй байгаа шалтгааныг нэг бүрчлэн дурдсан байна. АНУ-н зүгээс үзүүлж буй “Цөмийн аюул, Умард Солонгосыг цөмийн зэвсэггүй болгох, хүний эрх, нэмэлт хориг, хамтарсан цэргийн сургууль” зэрэг зэрэг дайсагнасан үйлдлээ зогсоохгүйгээр харилцаагаа сэргээхгүй гэж мэдэгджээ.

Чой Сон Хи дэд сайд дээрх дайсагнасан үйлдлүүдээ зогсоож, харилцаагаа сэргээх уур амьсгалыг бүрдүүлсэн цагт бид дахин харилцаагаа сэргээж болох юм гэсэн давхар санаа ч бас мэдэгдэлд агуулагдаж байна. Ким Ё Жон, Чой Сон Хи нарын мэдэгдэлийн цаана агуулагдаж буй санааг АНУ хэрхэн хүлээж авахаас цаашдын өрнөх үйл явц шалтгаалах төлөвтэй байна.

⁹ БНАСАУ 3-р сард нийт 5 удаа мэдэгдэл гаргаж, 3-р сарын 25-ны өдөр Япон тэнгис рүү удаа балластик пуужин харвав. <http://www.rodong.rep.kp/>

¹⁰ <http://www.kcna.kp/kcna.user.article.retrieveNewsViewInfoList.kcmsf.jsessionid=5FF195255A86B991EA5F51B438445C80#this>

¹¹ <https://biz.sbs.co.kr/article/20000007509?division=DAUM>

¹² <https://100.daum.net/encyclopedia/view/47XXXXXb1704>

¹³ <http://www.rodong.rep.kp/>

Мөн дээрх хоёр мэдэгдлийг олон улсын хэмжээнд өөр өөрөөр дүгнэж байна. Нэг хэсэг нь үе үе Солонгосын хойгт даамжирдаг хямралын эхлэл рүү эргэн очиж байна гэж үзэж байгаа бол нөгөө хэсэг нь яриа хэлэлцээ эхлүүлэх зайлшгүй шаардлага гарч эхлэхийн нааштай дохио хэмээн дүгнэж байна.

Умард Солонгосын Батлан хамгаалах шинжлэх ухааны хүрээлэн 3-р сарын 25-ны өдөр сүүлийн үед хөгжүүлэлт хийсэн шинэ төрлийн тактикийн балластик пуужинг¹⁴ харваж энэ тухай Хөдөлмөрийн намын Цэргийн төв хорооны орлогч дарга Ри Бён Чоль мэдэгдэл¹⁵ гаргасан. Энэхүү мэдэгдэлд “бидний хөгжүүлсэн шинэ төрлийн тактикийн балластик пуужин бол манай нам төр батлан хамгаалах чадварыг бэхжүүлэхийн төлөө батлан хамгаалах зорилтуудаа биелүүлэх хүрээнд хийгдэж буй бөгөөд тусгаар улсын хувьд өөрсдийгөө батлан хамгаалах” үйл юм. Түүнчлэн “Өмнөд Солонгос болон АНУ-н аюул заналхийлж буй цэргийн сургуулилт хийж Солонгосын хойгт цэргийн аюул түгшүүрийг бүрдүүлж байгаа энэ цаг үед манай улсын аюулгүй байдлыг баттай хамгаалахын тулд авч буй арга хэмжээ бөгөөд АНУ-н шинэ засгийн газрийн манайд хандаж буй хандлага биднийг аль замыг сонгох ёстойг дахин харуулж, бидний хийж буй үйлдэл зохистой үйл явдал юм гэж мэдэгджээ.

Умард Солонгосын Үндэсний Олимпийн Хороо 3-р сарын 25-ны өдөр хуралдаж дэлхий нийтээр тархаад буй цар тахлаас баг тамирчидаа хамгаалахын тулд гишүүдийн саналаар XXXII дах удаагийн Токио олимпод оролцохгүй байх шийдвэр гаргажээ.

Дүгнэлт

Солонгосын хойгийн эргэн тойронд болсон үйл явдлыг судлаачийн хувьд дараах байдлаар товч дүгнэж болохоор байна.

АНУ-н хувьд

- АНУ-н Ж.Байдений засгийн газрын Солонгосын хойгийн талаарх гадаад бодлого боловсруулалтын эцсийн шатандаа яваа бөгөөд одоогийн байдлаар Япон, Солонгос холбоотны улсуудтай зөвшилцсөн байдалтай байна.
- Мөн ерөнхийлөгч Ж.Байден 4-р сард Уур амьсгалын дээд хэмжээний уулзалтад 40 гаруй орны удирдагчдыг урьсан. Энэхүү дээд хэмжээний уулзалтад БНХАУ, ОХУ-н төрийн тэргүүн нар багтсан байгаа нь ихээхэн анхаарал татаж буй бөгөөд энэ уулзалтын дараа Солонгосын хойгийн талаар авч хэрэгжүүлэх бодлогоо танилцуулах болов уу гэсэн урьдчилсан таамгийг дэвшүүлж байна.
- Юутай ч Ханойн дээд хэмжээний уулзалтаас хойш зогсонги байдалд ороод байсан АНУ-БНАСАУ сэргэх үү, харин Солонгосын хойгийн нөхцөл байдал одоогийн нөхцөл байдал үргэлжлэх үү гэдэг асуудал одоогоор тодорхойгүй байна.
- АНУ-н засгийн газрын зүгээс гадаад бодлогын гол цөм нь хүний эрхийн асуудал байх болно гэж мэдэгдэхийн сацуу Умард Солонгосын дэглэм, хүний эрхийг ноцтой зөрчиж байгаа гэж мэдэгдэж байгаа нь ойрын хугацаанд энэ хоёр улсын харилцаанд нааштай өөрчлөлт гарахгүй байх магадлалтай гэж одоогийн байдлаар дүгнэх үндэслэл болж байна.
- АНУ-н шинэ засгийн газрын зүгээс Умард Солонгостой Солонгосын хойгийн цөмийн зэвсгийн асуудлаар хэлэлцээрт орохыг одоогоор яарахгүй байна.
- Умард Солонгосын хувьд АНУ-н дайсагнасан бодлого, тогтмол зохион байгуулж ирсэн цэргийн сургуулилтад эргэлзсэн хэвээр байна. Ийм нөхцөл байдалд АНУ-БНАСАУ хоёр яриа хэлэлцээг дахин сэргээлээ ч гэсэн тодорхой үр дүнд хүрч чадах эсэх нь одоогоор тодорхой бус байна.

БНСУ-н хувьд

- БНСУ-н Мүн Жэ Ин ерөнхийлөгч болсон цагаасаа Умард Солонгостой харилцаагаа сэргээхээр ихээхэн ач холбогдол өгч ирсний үр дүнд Панмүнжом, Пхьянян хотод Умард Солонгосын төрийн зөвлөлийн дарга Ким Жөн Унтай уулзалт хийж Солонгосын хойгийн талаарх асуудлаар нааштай уур амьсгалыг бүрдүүлж чадсан ч АНУ-БНАСАУ-н төрийн тэргүүн нарын Ханойн уулзалтаас хойш хоёр Солонгосын харилцаанд онцын ахиц дэвшил гарсангүй.
- Мүн Жэ Ин ерөнхийлөгчийн хувьд ерөнхийлөгчөөр ажиллах хугацаа 1 жил гаруй үлдээд байгаа бөгөөд үлдэж буй нэг жилд Солонгосын хойгийн асуудалд онцгой анхаарал хандуулна гэж мэдэгдэж байгаа боловч Өмнөд Солонгост болж буй улс төрийн нөхцөл байдал, ирэх жилийн сонгуулийн бэлтгэл гээд дотоод улс төрд нэн тэргүүнд шийдвэрлэх илүү их асуудал түүнийг хүлээж байна.
- Өнгөрсөн 4-р сарын 7-ний өдөр зохион байгуулагдсан Сөүл, Пусан хотын дарга нарын нөхөн сонгуульд Мүн Жэ Ин ерөнхийлөгчийн Минжү/ардчилсан/ нам ялагдсан нь дотоодын улс төрдөө анхаарал хандуулах нөхцөл болж өгч байна.

¹⁴ http://www.rodong.rep.kp/ko/index.php?strPageID=SF01_02_01&newsID=2021-03-26-0003

¹⁵ <http://www.kcna.kp/kcna.user.article.retrieveNewsViewInfoList.kcmsf?jsessionId=2C9B2FA8C5EB8D596B14264A6FA0427B#this>

- Сөүл, Пусан хотын даргын нөхөн сонгууль нь ирэх жил болох Ерөнхийлөгчийн сонгуулийн “өнгийг тодорхойлох” чухал сонгууль болдог тул энэ сонгуульд ялагдсан нь дээрх дурдсан нөхцөлийг бүрдүүлж өгч байна.

Япон улсын хувьд

- Япон улсын хувьд Умард Солонгост барьцаалагдсан Япон иргэдийн¹⁶ асуудлыг шийдвэрлэх нь гадаад бодлогын нэн тэргүүний зорилт гэж үздэг бөгөөд Япон улсын Ерөнхий сайд Сүга Ёшихидо удаа дараа барьцаалагдсан иргэдийн асуудлаар Ким Жөн Унтай уулзаж хэлэлцээр хийхэд бэлэн гэж мэдэгдэж ирсэн ч өнөөдрийг хүртэл Умард Солонгосын зүгээс ямар нэг хариу өгөөгүй байна.
- Мөн Умард Солонгосын балластик пуужин хөгжүүлэлт, 3-р сарын 25 өдөр харвасан баллистик пуужин Японы газар нутгийн зурвасаас ойрхон унасан зэрэг нь Япон улс өөрсдийн батлан хамгаалах салбараа бэхжүүлэх нэг хөшүүрэг болж өгч байна. БНАСАУ-н цөмийн зэвсгийн хөгжүүлэлт, балластик пуужингийн чадвар дээшлэх тусам Өмнөд дэх АНУ-н Пуужин эсэргүүцэх байгууламжийг байршуулж байсанчлан Солонгосын хойг дах АНУ-н цэргийн хүчийг нэмэгдүүлэх нь эргээд БНХАУ-н хувьд тийм ч таатай хандаж байгаагүй юм.
- Япон улс Токиогийн олимп Умард Солонгостой харилцаагаа сайжруулах ховор боломж хэмээн үзэж өнгөрсөн жилээс Ким Жөн Уныг Токиогийн олимпод урьж оролцуулах, олимпын үеэр хоёр улсын харилцааны чухал асуудлуудыг ярилцахаар төлөвлөж байна гэж мэдэгдэж байсан боловч Умард Солонгосын тамирчид олимпод оролцох эсэх нь одоогоор тодорхойгүй байна.
- Япон улсын хувьд АНУ-н зүгээс дэвшүүлж буй АНУ-Япон-БНСУ хамтран Солонгосын хойгийн цөмийн зэвсэггүй бүс болгох санаачилгыг идэвхтэй дэмжиж оролцохоо илэрхийлсэн. Хэдийгээр Өмнөд Солонгостой худалдааны маргаантай шийдвэрлэх асуудал байгаа ч аюулгүй байдлын асуудлыг тусад нь авч хамтран оролцох болсон.

БНАСАУ-н хувьд

- Өнгөрөгч 1-р сарын 4-12 өдрүүдэд Солонгосын хөдөлмөрийн (СХН) VIII-р их хурал хуралдлаа. Намын их хурал н тус намын эрх барих дээд байгууллага бөгөөд 5 жил тутамд нэг удаа хуралдаж өнгөрсөн 5 жилийн ажлаа дүгнэж, ирэх 5 жилийн зорилгоо тодорхойлсон. Их хурлаар сонгогдсон Төв хорооны бүх гишүүдийн хурлаас Төв хорооны Улс төрийн товчоо, Улс төрийн товчооны байнгын хорооны гишүүдийг сонгосон бөгөөд өргөн хэмжээний халаа сэлгээ хийснээр онцлог байлаа.
- Ханойн уулзалтаас хойш зогсонги байдалд ороод байсан АНУ, БНСУ-тай харилцах гадаад бодлогын чиг шугамаа танилцуулах байх гэсэн барууны судлаачдын хүлээлтийг эвдэж, тодорхой чиг шугам танилцуулаагүй бөгөөд уламжлалт хэв буюу “бурууд хатуу, зөвд зөөлөн” хандана гэсэн зарчмын шинж чанартай байр суурийг л илэрхийлсэн.
- Харин БНХАУ, ОХУ зэрэг уламжлалт найрсаг харилцаатай улс орнуудтай харилцах харилцаагаа хөгжүүлэн шинэ шатанд гаргах тухай тодорхой мэдээлж байсан бөгөөд Хөдөлмөрийн намын гадаад харилцааны хэлтсийн даргаар Ким Ир Сен, Ким Чен Ир дарга нарын орчуулгыг хариуцаж байсан хятадаар мэргэшсэн Ким Сөн Намыг томилсон бол Бээжинд суух элчин сайдаар Шадар сайд бөгөөд гадаад худалдааны сайд асан Ри Ён нам нарыг томилсон нь ирэх 5 жил Хятад улстай харилцаагаа хөгжүүлэх дээр онцгой анхаарах төлөвтэй байна.
- Мөн өнгөрөгч 3-р сард авсан сансарын хиймэл дагуулын зургаар Умард Солонгосын шумбагч онгоцны байгууламж, баллистик пуужингийн байгууламжуудад хүний хөдөлгөөн ихэссэн нь ойрын, болон дунд, алсын тусгалтай пуужин, зэвсэг хөгжүүлэлт идэвхитэй явагдаж байна гэсэн барууныхны болгоомжлолыг дагуулж байна.
- 4-р сарын эхээр болсон Хөдөлмөрийн намын анхан шатны нэгж, намын үүрүүдийн дарга нарын хурал дээр Ким Жөн Ун “бид урьд хожид байгаагүй амаргүй цаг үед амьдарч байгаа асар их бэрхшээлтэй нүүр тулж байгаа бөгөөд гадаад орчноос ойрын хугацаанд ямар нэг итгэл найдвар хүлээх хэрэггүй” гэсэн нь ойрын хугацаанд АНУ, БНСУ-тай яриа хэлэлцээрийн ширээнд суухгүй гэсэн байр суурь гэж ойлгогдож байна.

Дээрх бүхнээс нэгтгэн дүгнэж үзэхэд 2021 он гараад бүс нутгийн орнуудын Засгийн газрын түвшинд Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудлаар хамтран ажиллах, санал солилцох тодорхой оролдлогууд хийгдсээр байгаа нь тус бүс нутагт шинэ нөхцөл байдлыг бүрдүүлж байна. Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудал бүс нутгийн орнуудын холбоотон улсын харилцаа, хоёр талт болон олон талт хамтын ажиллагаа яриа хэлэлцээ хийх гол үндэс болж ирсэн. Өмнөх туршлагуудаас харахад Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн Умард-Өмнөд Солонгосын төрийн тэргүүн нарын уулзалт хангалтгүй бөгөөд АНУ, БНХАУ, ОХУ болон их гүрнүүдийн бүс нутгийн хүрэн дэх оролцоо тэр дундаа АНУ, Япон, АНУ-Өмнөд Солонгос холбоотны харилцаа, АНУ-БНХАУ, АНУ-ОХУ-БНХАУ,

¹⁶ <https://100.daum.net/encyclopedia/view/14XXE0066694> Барьцаалагдсан Япон иргэдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү.

АНУ-БНАСАУ харилцааны уулзвар дах хүчний тэнцвэрийн механизмууд Зүүн Хойд азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөөтэй.

Ном зүй

М.Багчимэг. Шатрын өрөг дэх Монгол, Улаанбаатар 2012.

Д.Отгонбаатар. “Солонгосын хөдөлмөрийн намын VIII их хурлын эргэн тойронд”. <https://niss.gov.mn/archives/2163> 2021.

Bob, Woodward. Rage. New York, Simon & Schuster. 2020.

Choi Kang. “How Should we see and Respond to North Korea?”. The Asan Institute for Policy Studies 2021

Lee, Ki-Dong. “WPK’s 8th Party Congress and the Change of Power Structure”. Institute for National Security Strategy. 2021.

Cho, Han Bum. “Changes to the National Strategy of the Kim Jong-Un Regime and the Limitation of Strategy of Self-Reliance”. Korean Institute for National Unification, Online series.2021.

Hwang, Jihwan. “Face-Saving, Reference Point and North Korea’s Strategic Assessment,” Korean Journal of International Studies, vol.49, no. 2(Summer 200): 55-75.

John Bolton. “The Room Where It Happened”. A White house Memoir. 2020

Lee, Sang-Sook. “Distinctive Characteristics of the 75th Anniversary Celebration of the Worker’s Party of Korea and Outlook for the 8th Party Congress”, Institute of Foreign Affairs and National Security, vol. IF2020-24E, 2021.

The Institute for Far Eastern Studies. “State of Affairs on the Korean Peninsula: Assessment of 2020, Prospect for 2021”. Korean Peninsula report, 2020